

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255012>

МОНГОЛ ХЭЛНИЙ ОРНЫ УТГАТ ҮГЭЭР ТАНИН МЭДЭХҮЙН  
ЗҮЙРЛЭЛ ИЛРЭХ НЬ

С.Энхжаргал

**Товчлол:** Энэхүү өгүүлэлд орчин цагийн монгол хэлний орон цагийн харьцаа заасан нэрсийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс Ж.Лакофф (George Lakoff), М.Жонсон (Mark Johnson) нарын дэвшүүлсэн танин мэдэхүйн зүйрлэл (Conceptual Metaphor Theory)-ийн онолд тулгуурлан шинжиллээ. Судалгаанд “Монгол хэлний цахим тайлбар толь бичиг” болон монгол хэлний төрөл бүрийн хэлц үг хэллэгийн толь бичгүүдээс орон цагийн нэрс бүхий өвөрмөц хэлцүүдийг түүвэрлэн авч, тэдгээрийн шууд ба шилжсэн утгын харьцааг задлан шинжилсэн болно.

Биеэр танин мэдэхүй буюу EMBODIED COGNITION онолд тулгуурлан “дээр, доор, өмнө, хойно, дотор, гадна, наана, цаана” зэрэг орны нэрс нь зөвхөн физик байршил заах бус, харин нийгмийн байр суурь, үнэлэмж, сэтгэл хөдлөл, ёс суртахуун, цаг хугацаа, амьдралын үйл явц зэрэг хийсвэр ойлголтыг дүрслэн илэрхийлэх танин мэдэхүйн үйл ажиллагааны үндсэн тулгуур болдгийг тогтоов.

Судалгааны үр дүнд монгол хэлэнд босоо чиглэлийн (ДЭЭР–ДООР) зүйрлэл давамгайлан GOOD IS UP / BAD IS DOWN загварыг илэрхийлж, “дотор” зэрэг үг нь СЭТГЭЛ БОЛ САВ гэсэн сав багтаамжийн (CONTAINER) зүйрлэлийн үндсэн дээр дотоод ертөнцийг дүрслэн илэрхийлж байгааг тогтоолоо. Мөн орон зайн эсрэгцэл нь монгол хүний сэтгэлгээнд хоёртын зохион байгуулалт бүхий тогтолцоо бүрдүүлж байгааг харуулж байна.

Ингэснээр орон цагийн нэрс нь монгол хэлний хийсвэр ухагдахууныг илэрхийлэх тулгуур ойлголт бөгөөд биед суурилсан, хүн төвт сэтгэлгээний онцлогийг хадгалсан хэлний нэгж болохыг тодруулан гаргав.

**Түлхүүр үг:** орон зайн нэр, биеэр танин мэдэхүй, өвөрмөц хэлц, туршлага, баримжааны зүйрлэл

**Keywords:** place-time nouns, embodied cognition, mongolian idioms, experience, orientational metaphors

Удиртгал

Танин мэдэхүйн хэл шинжлэлийн зүйрлэлийн онолын хүрээнд орон цагийн ойлголтуудыг зөвхөн физик орчинд бус, танин мэдэхүйн харьцуулалт, зүйрлэлээр дамжуулан хийсвэр ойлголтод шилждэг болохыг орчин үеийн хэл шинжлэлийн хэлний нийтлэг зарчмаар санал нэгтгэй хүлээн зөвшөөрөх болжээ. Энэ нь Ж.Лакофф, М.Жонсон нарын **Conceptual Metaphor Theory**-ийн гол зарчимтай шууд холбоотой бөгөөд “Our conceptual system is largely metaphorical, and our bodily experience provides the basis for it.” (Lakoff & Johnson, 1980, p. 19) “We understand abstract concepts in terms of more concrete concepts, typically grounded in our physical and spatial experience.” (Lakoff & Johnson, 1980, p. 59) гэх мэтээр “Хүний сэтгэлгээ гол төлөв зүйрлэлийн шинжтэй бөгөөд түүний суурь үндэс нь бидний биеийн туршлага юм”, “Бид хийсвэр ойлголтуудыг илүү танил, биеэр мэдрэгддэг орон

зайн туршлагаараа дамжуулан ойлгодог” гэсэн танин мэдэхүйн хэл шинжлэлийн суурь зарчим юм. Энэ нь “хүн нийгмийн оюун санаанд хуримтлагдсан туршлага, танин мэдэхүйн сэрэл, мэдрэхүйн талыг түлхүү барьж томъёолсон бөгөөд хүн харилцаандаа зүйрлэл хэрэглэх, хүний зүйрлэх сэтгэлгээний үндсийг үндэсний хэлтэй нь биш, сэтгэлгээнийх нь хэв шинж, соёл-сэтгэлгээтэй нь илүүтэй холбож үзсэн” (Магсар, 2012: 59) байдаг.

Ж.Лакофф, М.Жонсон нарын танин мэдэхүйн зүйрлэлийн онолд зүг чигийн (баримжааны) зүйрлэлүүд (orientational metaphors) чухал байр суурь эзэлдэг. Тэд “Metaphors We Live By” (1980) бүтээлдээ баримжааны зүйрлэлийг хүний орон зайн сэтгэлгээ, туршлага дээр тулгуурласан танин мэдэхүйн зүйрлэл (metaphor)-ийн үндсэн төрөл гэж тодорхойлсон. Энэ нь хүн төрөлхтөн өөрсдийн ухамсар, мэдрэмж, сэтгэл санааны төлөв байдлыг орон зайн чиглэлээр (up-down, in-out, front-back, etc.) зохион байгуулж, илэрхийлдэг гэж үздэг. Тодруулбал: “Ихэнх зүйрлэл нь орон зайн баримжааллын загварт суурилсан шинжтэй байдаг. Үүнд: дээр-доор, дотор-гадна, өмнө-хойно, идэвхтэй-идэвхгүй, гүн-гүехэн, төв-зах зэрэг чиглэлийн эсрэгцэл хамаарна. Эдгээр баримжаалал нь хүний бие махбодын бүтэц, бодит орчинтой харилцах үйл ажиллагааны онцлогоос үүдэн бүрэлдэн тогтдог” буюу “Many metaphors are spatial in nature, having to do with orientation in space: up-down, in-out, front-back, on-off, deep-shallow, central-peripheral. These spatial orientations arise from the fact that we have bodies of the sort we have and that they function as they do in our physical environment” (Lakoff, G. & Johnson, M. 1980: 14) гэжээ. Уг онолоор хүний орон зайн туршлага нь сэтгэлгээний хийсвэр ойлголтуудыг бүтээх суурь схем болдог гэсэн нь сонирхолтой бөгөөд бидний судалгааны үндэслэл болж байгаа юм.

Дараах байдлаар загварчлан харж болно.

- **UP** → **Positive / High status**

“Албан тушаал дэвших” (дээш чиглэл = илүү эрх мэдэл, амжилт)

- **DOWN** → **Negative / Decline**

“Бууран доройтох” (доош чиглэл = бууралт, сөрөг байдал)

- **IN** → **Involvement / Inclusion**

“Хэлэлцүүлэгт орох” (дотор орох = үйл ажиллагаанд нэгдэх)

- **OUT** → **Exclusion / Escape**

“Асуудлаас гарах” (гадна гарах = асуудлаас чөлөөлөгдөх)

Лакофф ба Жонсон нарын үзлээр, **хийсвэр ойлголт** (target domain) нь дангаараа ойлгогдох боломжгүй. Тиймээс хүн түүнийг **биеийн туршлагад суурилсан эх сурвалжийн хүрээгээр** (source domain) дамжуулж ойлгож, туршлага бүтээдэг. Энэ нь “**embodied cognition**” (**биеэр танин мэдэхүй**) хэмээх танин мэдэхүйн онолын үндэс суурьтай нийцдэг. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн сэтгэлгээ нь тархинд тусгаар оршдоггүй, харин биеийн мэдрэмж, хөдөлгөөн, орон зайн харьцаатай салшгүй холбоотой юм. Жишээлбэл, “дээр гарах” гэсэн холбоо үгийн утга нь зөвхөн физик хөдөлгөөн бус, амжилт, давуу байдлыг илэрхийлсэн зүйрлэл болсон байна.

Ийм төрлийн зүйрлэлийг хүн бүр өдөр тутам хэрэглэдэг, ойлгож ухаардаг бөгөөд хоёр туйлт бүтэцтэй байна. Жишээлбэл:

**HAPPY IS UP / SAD IS DOWN**

“I’m feeling up today.” (Би өнөөдөр сэтгэл өндөр байна.)

“He’s really down these days.” (Тэр сүүлийн үед гутранги байна.)

## Судалгааны үндэслэл

Монгол хэлэнд дээрх жишээтэй адил “сэтгэл өндөр”, “гутран унах” гэх мэтчилэн ижил төрлийн зүйрлэл түгээмэл ажиглагдана. Энэ тухайд А.Цог-Очир “орон зайн “дээр”, “дээш”, “өөдөө” гэсэн баримжаа нь эерэг сайны ойлголт, үнэлэмжтэй зохицож, хэлний ухамсарт суусан нь хүн төрөлхтний сэтгэлгээнд нийтлэг болсон зүйл юм” гээд “...монгол хэлний дээр цаг, дээр үе, дээр үеийн хүмүүс, дээд үе, өвөг дээдэс гэдэг хэллэгт буй энэхүү дээр, дээд, дээдэс гэдэг үг нь дээр доорын ялгалын утга, далд мэдэгдэхүүний талаасаа бас хүндэтгэлийн утга илтгэж байна. Гэхдээ танин мэдэхүйн туршлагын үүднээс буюу зүг чигийн баримжааны танин мэдэхүйн учир холбогдлын талаасаа тодорхой бус, мэдэгдэхгүй байгаа зүйл нь “дээд тал”, “дээр”, “дээшээ”-г баримжаалдаг гэсэн үзэл байдаг. Иймээс “эрт” гэдэг нь өнгөрсөн цагийн утга, дээр гэдэг нь орны утга илтгэх боловч үл мэдэгдэх гэсэн утгаар үе, цаг гэсэн үгийг тодотгож, улмаар “өнгөрсөн, үл мэдэгдэх үе” хэмээсэн утга бүхий нэгэн бүхэл хэллэг болж байна (А.Цог-Очир, 2019:46) гэжээ. Энэ мэтээр монгол хэлний орон цагийн нэрээр илрэх шилжсэн утгын зүйлсийг танин мэдэхүйн зүйрлэлийн онолын үүднээс тодруулан үзвэл нэн сонирхолтой юм.

Орон, цагийн нэрс нь хэлцийн бүрэлдэхүүнд орсноор утга шилжүүлэх буюу зүйрлэлийн үүднээс хэрэглэгддэг бөгөөд энэ нь бидний орчныг, мөн цаг хугацааг хэрхэн төсөөлж, ойлгодогтой шууд холбоотой. Хүн зүйрлэлээр дамжуулан орон зайн ойлголтыг зөвхөн физик байршил биш, харин сэтгэл зүйн, нийгмийн болон цаг хугацааны элементүүдтэй холбож ойлгодог тухай бид тодруулан үзэх болно.

Монгол хэлний дээр, доор, өмнө, хойно, гадна, дотно, гадар, дотор, хажууд гэх мэт үгийг урьд нь холбоо үгийн бүтцэд биеэ даасан үгийг дагаж орох өгүүлбэр зүйн байрлалд нь үндэслэж дайвар үг, дагавар үг гэх мэтээр нэрлэдэг байснаа нэрийн тийн ялгалын нөхцөлөөр хувилж, орон цагийн утга илэрхийлдэг шинжид нь үндэслэж, Ш.Лувсанвандан орон цагийн харьцааны нэр хэмээн нэрлэж нэрийн аймагт хамааруулсан байдаг. Эдгээр үгийн утга, хэрэглээний онцлогийг орчин үеийн хэл шинжлэлийн онолын үүднээс судлан шинжлэх нь монгол хэл шинжлэлд үгүйлэгдэж байгаа орон зай гэж үзэж болно. Тухайлбал: орших орны утга илэрхийлэх **дээр** хэмээх үгийг монгол хэлэнд 10 орчим утгаар хэрэглэж байгааг монгол хэлний тайлбар толиудаас харж болно. Тухайлбал: 1.доор гэдгийн эсрэг утга, 2.Түрүүн, эрт, урьд, 3.Гадна, тусгай, 4.Чанараар илүү давуу, сайн, 5.Дээш, өөд, 6.Даруйд нь, тэр дор нь, 7.Нэрийн дор, 8.Улам ахих, цаашлах, 9.Орон заах утга, 10. Бусад үгтэй нийлж янз бүрийн утга санааг илэрхийлнэ. Чухам энэхүү 10 дугаарт холбогдох утгын талаар бид дэлгэрүүлж судлах зорилго тавилаа. Тайлбар толь бичигт дурдаагүй өөр ямар утга байж болохыг мэдэхийн тулд монгол хэлний хэлц үгийн толь бичгүүдээс **дээр** гэсэн үг бүхий өвөрмөц хэлцийг түүвэрлэн авч, задлан шинжилж үзэхэд, орших буюу зогсонги орны утга илэрхийлэх үндсэн утгаас гадна өвөрмөц хэлцийн бүтцэд орсноор төрөл бүрийн шилжсэн утга илэрхийлэх боломжтой байна. Жишээ нь: **толгой дээр гарах** - а.эрх хэмжээнээс хэтэрч улам даврах, цаашлах, өөгших; **аман дээр гарч ирэх** - хэлэхээ шахах, **дээр доороо орох** - а.хэрэлдэх, хараалцах, б.зарим юмны бужигнах байдал, **нас дээр гарах** – өтлөх, хөгшрөх, **ноцсон гал дээр тос нэмэх** – байдлыг улам хүндрүүлэх, **нүд нь орой дээрээ гарах** – гайхах гэх мэт хэлц үгийн бүтцэд орж шинэ нэрлэлт үүсгэж буй утгын болоод хэрэглээний онцлогийг орчин үеийн танин мэдэхүйн хэл шинжлэлийн хүн төвт үзэл, биед суурилсан танин мэдэхүй, зүйрлэлийн онолын үүднээс авч үзэх нь монгол хэл шинжлэлд шинэлэг судалгаа юм.

“Тодорхой үндэстэн угсаатны тухайд тэдний уламжлалт оюуны соёлын мөн чанар нь тэдний сэтгэлгээний тогтвортой хэв шинж болдог” (Ж.Баянсан, 2016:37) гэж үзэх бөгөөд үндэсний сэтгэлгээний онцлогийг тайлбарлахын тулд танин мэдэхүйн хэл шинжлэлийн өнөөгийн чиг хандлага болж буй Ж.Лакофф, М.Жонсон нарын танин мэдэхүйн зүйрлэл (cognitive conceptual metaphor)-ийн онолыг баримтлах нь зүйтэй гэж үзлээ.

### Судалгааны арга, арга зүй

Энэхүү судалгаа нь монгол хэлний орон зайн нэрсийн утга, хэрэглээний онцлогийг танин мэдэхүйн хэл шинжлэлийн онол, чиг хандлагаар судлахад чиглэсэн. Судалгааны гол зорилго нь хэлц үгийн орон зайн утгыг танин мэдэхүйн зүйрлэлийн онол (Conceptual Metaphor Theory; Lakoff & Johnson, 1980) болон биеэр танин мэдэхүйн (embodied cognition) хүрээнд системтэйгээр тодорхойлох явдал байв.

1. **Онолын суурь:** Судалгаа нь танин мэдэхүйн зүйрлэлийн онол, танин мэдэхүйн хэл шинжлэлийн суурь зарчмууд, мөн бие махбодын туршлагад суурилсан танин мэдэхүйн үзэл санаанд тулгуурласан. Энэ нь монгол хэлний орон зайн нэрсийг зөвхөн физик байрлал илэрхийлдэг хэмжүүрээс гадна, сэтгэл зүйн, нийгмийн болон цаг хугацааны ойлголтод хэрхэн шингэсэн болохыг илрүүлэхэд чиглэв.

2. **Баримт цуглуулах арга:** Урьд өмнө хэвлэгдсэн монгол хэлний хэлц үг, хэллэгийн тайлбар толь бичгүүд болон Монгол хэлний цахим их тайлбар толь зэргээс монгол хэлний орон зайн нэрсийг агуулсан хэлц үгийг түүвэрлэн цуглуулж орон цагийн нэрс бүхий хэлц үгийн сан бүрдүүлсэн.

3. **Ажиглалт ба харьцуулалт:** Цуглуулсан хэлц үгийн шууд болон шилжсэн утгыг орон зайн эсрэгцэл (дээр–доор, өмнө–хойно, наана–цаана) болон танин мэдэхүйн бүтэц, зохион байгуулалтын талаас системтэйгээр ажиглаж, харьцуулсан.

4. **Ангилал, бүлэглэх:** Хэлц үгийг ухагдахууны загвар, утгын хүрээний онцлог, орон зайн чиглэлээр ангилан зохион байгуулсан. Жишээлбэл: босоо чиглэлийн (UP–DOWN) хэлц нь үнэлэмж, сэтгэл хөдлөл, байр суурь, хөдөлгөөнтэй холбоотой бол, сав багтаамж (IN–OUT) схем нь дотоод ертөнцийн дүрслэлийг илэрхийлдэг.

5. **Чанарын дүн шинжилгээ (Qualitative analysis):** Өгүүлбэр, хэлцийн орон зайн болон бие махбодын элементийг чанарын аргаар судалж, зүйрлэлийн хэлбэрийг тогтоосон. Энэ арга нь монгол хэлний хэлцийн утга шилжилт, давтагдсан хэв шинжийг илрүүлэхэд дэмжлэг болсон.

6. **Герменевтик тайлбар (Hermeneutic interpretation):** Хэлцийн утгыг хүний туршлага, нийгмийн байр суурь, цаг хугацааны ойлголттой холбон тайлбарлаж, хэлц үгийн утга нь зөвхөн үгийн шууд утга бус, бие махбодын, орон зайд суурилсан, нийгмийн болон сэтгэл зүйн ойлголттой нягт холбоотой болохыг тодруулсан.

### Судалгааны хэрэглэгдэхүүн

Судалгааг тогтолцоотой болгохын тулд монгол хэлний орны харьцаа заах үгсийг аль болохоор бүрэн хамруулах нь зүйд нийцэх тул *дээр, доор, гадар, дотор, гадна дотно, өмнө, хойно, ард, урд, ураги, хойш, хажууд, дэргэд, завсар, ойр, хол* гэх мэт үгээс бүтсэн өвөрмөц хэлцүүдийг хамруулан урьд өмнө хэвлэгдсэн монгол хэлний хэлц үг хэллэгийн толь бичгүүдийг судалгааны хэрэглэгдэхүүн болгов. Үүнд:

- Монгол хэлний цахим их тайлбар толь
- Чой.Лувсанжав “Орос -монгол өвөрмөц хэллэгийн толь” Уб., 1970,

- Г.Эрдэнэ-Очир “Зарим зүйр цэцэн үгийн товч толь” Уб., 1983,
- Г.Аким “Монгол-орос, орос-монгол өвөрмөц хэлцийн товч толь” Уб., 1985,
- Г.Аким “Монгол хэлний өвөрмөц хэлцийн товч тайлбар толь” Уб., 1982, 1999,
- Ж.Бат-Ирээдүй “Зүйр цэцэн үгийн зүйлээр хуваасан толь” Уб., 2005,
- Ж.Бат-Ирээдүй “Монгол хэлний хэлцийн сан” Уб., 2009,
- “Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь” эмхэтгэсэн Г.Сүлд-Эрдэнэ нар. Монсудар. Уб., 2011,
- “Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь” эмхэтгэсэн С.Чулуунпүрэв. Монсудар. Уб., 2011,
- Л.Дашням “Монгол хэвшмэл хэллэг, хэлц үгийн тайлбар толь” Үүдэн өлзий. Уб., 2014. 271-387-р тал.
- Н.Ням-Осор, Б.Өлзийсүрэн “Монгол хэлний зүйр, цэцэн үгийн товч тайлбар толь” Уб., 2011,
- Б.Өлзийсүрэн “Монгол цэц ухаан буюу түмэн толгой зүйр цэцэн үгийн түлхүүр” Уб., 2015,
- Ш.Нарантуяа “Монгол хэлц үгийн тайлбар толь” Уб., 2017,
- Н.Баяртогтох “Оюун билгийн сан хөмрөг” түмэн өвөрмөц хэлцийн зүйлчилсэн тайлбар толь. Уб., 2017.

### Судалгааны хэсэг

Танин мэдэхүйн хэл шинжлэлийн үзэл онолоор хэлний утга бол бидний бие цогц, бие эрхтэн, тархи мэдрэлийн үйлтэй холбоо хамааралтай байдаг. Бид ертөнцтэй хэрхэн харилцаж, нөлөөлцөж байна вэ гэдэг нь хэлний утгын орон, утгын байрыг тодорхойлж байдаг. Тийм ч учраас танин мэдэхүйн хэл шинжлэлийн утгын тухай суурь онолд бие цогц, бие эрхтний харилцан үйлчлэлийг илэрхийлсэн утга бий болдог гэж үздэг. Биеэр танин мэдэхүй буюу embodied cognition гэсэн ойлголтоор үгийн утга, танин мэдэхүйн утгын тухай тодорхойлох боломжтой юм. Бидний эргэн тойрны бүхий л юмс, үйл явдал бидний өөрсдийн харах өнцгөөс хамааралтай байдаг. Тийм ч учраас өөрөөрөө төв болгон орчлонг үзэх үзэл хандлага орчин үеийн хэл шинжлэлд бий болжээ. Энэхүү өөрөөрөө төв болгох буюу бие төвт үзэл гэдэг нь бидний хэлийг хэрэглэх явц дунд илэрдэг. Бид өөрсдийн ярьж байх үеийнхээ орон зайн байрлал дээр тулгуурлаад бусад биетийн орон зайн байрлалыг тодорхойлж ярьдаг. Бидний байрлаж байгаа газрыг “энд” (here) гэж нэрлэнэ. Бидний яг одоо ярьж байгаа цагийг “одоо” (now) гэж нэрлэнэ. Хэрвээ би “манай багш яг одоо энд байна” гэж яривал намайг сонсож байгаа хүн “энд” гэдэг нь миний байгаа газрыг зааж байгааг мэдэх бөгөөд “одоо” гэдэг нь би яг одоо ярьж байх үеийн хугацаа гэж ойлгоно. Иймээс бид өөрийн мэддэг зүйлээрээ дамжуулан мэдэхгүй зүйлийг танин мэдэх арга барилыг эзэмшсэн байдаг. Жишээ нь: “дээр”, “доор” гэсэн орон зайн танилт нь бие махбод болон хүндийн хүчний харилцан хамаарлаас бий болсон гадаад ертөнцийн ойлголт юм. Ер нь ямар ч хэлэнд хүнээс ангид “дээр”, “доор” гэсэн оршихуй байхгүй гэж болно.

Монгол хэлний хувьд орон цагийн нэр нь биеэ даасан үгийн аймаг уу, эсвэл дайвар үгийн бүрэлдэхүүний нэг хэсэг үү, аль эсвэл хэд хэдэн үгийн аймагт хамаарагдах завсрын шинжтэй үгс үү гэдэг талаар санал зөрөөтэй явсаар иржээ. Зарим эрдэмтэн (Санжеев, 1941; Тодаева, 1951; Лувсанвандан, 1955; Эрдэнэбагана, 1975) эдгээр бүлэг үгийг өгүүлбэрт гүйцэтгэх үүргээр нь гол шалгуур болгон тэмдэг нэр, дайвар үг, дагавар үгийн аль алинд хамааруулж байв. Тухайн үгсийн утга, үг зүйн шинжийг үл анхаарснаас хэд хэдэн үгийн аймгийн завсрын шинжтэй

гэж үзсэн дутагдалтай. Энэхүү дутагдлыг Ш.Барайшир (1966, 1974) анзаарч зөвхөн дайвар үгэнд хамааруулж орон заах дайвар үг гэж нэрлэсэн. Хэдийгээр утга болоод хэл зүйн онцлогийг нарийн тодорхойлсон боловч бие даасан утгагүй, хэл зүйн хувиллаар хувилдаггүй, өгүүлбэрт бие дааж гишүүн болдоггүй маш, нэн, тун, хага, хуга, цоо гэх мэт үгтэй нэг аймагт багтаасан нь мөн буруу болжээ. 1966 оны “Орчин цагийн монгол хэл зүй” бүтээлд орон заах дайвар үг (186) гэж үзсэн байдаг. Харин Ш.Лувсанвандан орон цагийн харьцааны нэр (1968), П.Бямбасан орон цагийн нэр (1989), Чойжинжав орны нэр (1987), Ч.Бямбаханд орон цагийн харьцааны нэр (2017) гэж нэрлэн биеэ даасан үгийн аймаг болгож нэр үгийн аймагт хамааруулсан байна.

Ч.Бямбаханд монгол хэлний орон цагийн харьцааны нэрийг тусгайлан судалж утга, бүтцийн онцлогийг шинээр тодорхойлохдоо “монгол хэлний дайвар үгийг судалсан эрдэмтэн мэргэдийн санал нэгдмэл бус өөр өөр өнцгөөс харж судалсан нь орон цагийн харьцааны нэр нь хэлний нарийн ээдрээтэй асуудал төдийгүй их хөдөлгөөнтэй хосолмол, завсрын шинжит ойлголт болох нь гарцаагүй байна” (2017: 53) гэж үзжээ. Мөн орон цагийн харьцааны нэрс шууд бус нэрлэлтэд тодорхой үүрэгтэй байгааг олон жишээгээр задлан шинжилж “...орон цагийн харьцааны нэр нь хэлцийн утгад холбогдолтойн дээр...туслах үгийн үүргээр ордог ч утгын талаас үйл явдлыг тодорхой орон цагт төлөөлүүлж эсвэл дүрсэлж илэрхийлдэг. ...орон зай, цаг хугацааны ерөнхий утгыг хадгалж байгаа ч заримдаа утга нь бүрэн шилжинэ” гэх мэтээр утга шилжиж шууд бус нэрлэлт бүтээж байгаа тухайд тодорхой өгүүлсэн байна.

Монгол хэлэнд цагийн нэр нь орны нэрээсээ цөөн тул орны нэр нь цагийн утгаар хэрэглэгддэг. Энэ тухайд Ж.Баянсан: “Монгол хэлэнд *өмнө* гэдэг нь орон, цагийн аль ч утгаар хэрэглэгдэж болдог бөгөөд хам сэдвээс ойлгомжтой болдог. Жишээлбэл, *ширээ самбарын өмнө байна* гэхэд орон заасан утгаар, гэтэл *нэг жилийн өмнө би оюутан байсан* гэвэл цагийн утгаар оржээ. Харин англи хэлэнд *before* нь зөвхөн цаг заасан утгаар хэрэглэгддэг бол *front or front of* гэвэл орон заадаг. ...судалгааны үүднээс бол хүн төрөлхтөн эрт үедээ орон, цагийг ялгадаггүй байсныг гэрчилж байгаа бөгөөд одоогийн хүмүүс орон цагийг хэдийгээр тодорхой ялгаж ойлгодог ч гэсэн нэг хэлэндээ хэлний тэмдэг нь ялгаатай байхад нөгөө хэлэндээ ижил байдаг аж” (2022: 85) хэмээн тайлбарлажээ. Энэ мэт ялгаатай байдал хийгээд эрдэмтэн судлаачдын зөрүүтэй санал дэвшүүлж байсны учир шалтгааныг бид нарийвчлан судлах зорилго тавихгүй ч өгүүлбэрт гүйцэтгэх үүргээрээ үйл үгтэй, бүтээвэр зүйн шинжээрээ нэр үгийн шинжтэй эдгээр бүлэг үгийн утга, хэрэглээний онцлогийг өвөрмөц хэлцийн бүтцээс орчин үеийн хэл шинжлэлийн чиг хандлагаар эрэлхийлбэл сонирхолтой юм.

Бид өмнө өгүүлсэн жишээ баримтаа баяжуулан үргэлжлүүлж дээр, дээгүүр, дээрдэх гэх мэт үгээр бүтсэн хэлцүүдийг жагсаавал: *дээр гарах, дээр нь гарах, толгой дээр гарах, толгой дээр суух, нас дээр гарах, нүд нь орой дээрээ гарах, дээгүүр зантай, дээгүүр албан тушаал, дээгүүр давхих, газар дээрдэх, бие дээрдэх, ажил дээрдэх* гэх мэт.

Доор, доогуур, доордох үгсээр бүтсэн хэлцүүд: *гарын доор, доорд үзэх, доороо эргэлдэх, доогуур үзэх, доогуур харцтай, доош хийх, доош нь чихэх, доошоо орох* гэх мэт байна. Дээр-доор харилцан эсрэгцсэн харьцааг хүснэгтээр илэрхийлбэл:

Хүснэгт 1. “Дээр” ба “доор” ойлголтын эсрэгцлэл (conceptual opposition)

Илэрхийлэл	Эерэг чиглэл (UP)	Сөрөг чиглэл (DOWN)
байр суурь	дээр гарах – дэвших	доошоо орох – байр сууриа алдах
түвшин	ажил дээрдэх – амжилттай	доош хийх – үнэлэмж буурах
сэтгэл хөдлөл	нүд нь орой дээр гарах – сэргэх	доогуур харцтай – дорой, гунигтай
хүч	толгой дээр суух – эрх мэдэлтэй	гарын доор – захирагдах
цаг хугацаа / өөрчлөлт	нас дээр гарах – өсөх, төлөвших	доордох – чанар муудах

Хүснэгт 1-ээс харахад дээр, доор гэсэн орны утгат үгс хэлцийн бүрэлдэхүүнд орсноор аливаа зүйлсийн байр суурь, түвшин, сэтгэл хөдлөл, хүч чадал, цаг хугацаа, өөрчлөлт хувирал зэрэг хийсвэр ойлголтыг илэрхийлж байна. Харин “Монгол хэлний цахим тайлбар толь бичиг”-ээс өмнө – хойно гэсэн үгээс бүтсэн хэлцүүдийг ажиглавал:

1. Орон зайн эсрэгцлээр нийгмийн харилцаа, үйл хандлага, зан үйлийг илэрхийлж байна. Жишээ нь: *нүдний өмнө* — “илэн далангүй, нууж хаахгүй”, *хүний өмнөөс* — “хэн нэгний оронд, түүний төлөө”, *хойш суух* — “идэвхгүй байх”, *өмнө хойно гүйх* — “зусардах, бялдуучлах” гэх мэт. Өөрөөр хэлбэл, орон зай бол нийгмийн байр суурь, нийгмийн харилцаа гэсэн танин мэдэхүйн зүйрлэл үүсэж байна.
2. Цаг хугацааны зүйрлэл үүсэж байна. Жишээ нь: *хойш тавих, хойшлуулах* — “цаг хугацааг сунгах”, *хойш харах* — “өнгөрснийг бодох” гэх мэт. Монгол хэлэнд цаг хугацаа нь орон зайгаар дүрслэгддэг. Энэ нь танин мэдэхүйн зүйрлэлийн **цаг хугацаа бол орон зай** гэсэн зүйрлэлийн сонгодог жишээ юм. Өөрөөр хэлбэл: Өнгөрсөн бол ард/хойно, Ирээдүй бол урд/өмнө гэсэн зүйрлэл болно.
3. Үүрэг, дүрийн (Role / Representation) зүйрлэл үүсэж байна. Жишээ нь: *хүний өмнөөс хариуцах, хүний өмнөөс ярих* гэсэн хэлцэд “түүний оронд, төлөөлж үйлдэх” гэсэн утга илэрхийлэх бөгөөд *биеийн байрлал (өмнө / ард)* нь *нийгмийн харилцаа дахь оролцоо, хариуцлагыг* илэрхийлж **үүрэг бол байрлал** гэсэн зүйрлэл илэрч байна.
4. Хэлц үгсийн бүрэлдэхүүнээс харахад “өмнө” нь **идэвх, ил тод байдал, амьдрал, ирээдүй**-г илтгэж, харин “хойно” нь **идэвхгүй, өнгөрсөн, доройтол**-ын утгын хүрээтэй холбогдож байна.

Урд, урагш, урагшлах гэсэн орон зайн үгтэй хэлцүүдийг авч үзэхэд: *урдаа барих, урагш муутай, урагшгүй, урагшгүйтэх* гэх мэт байна. Урд, урагш чиглэл нь монгол сэтгэлгээнд амьдралыг хөдөлгөөн гэж үзэхтэй салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, урагшлах нь зөвхөн орон зайн хөдөлгөөн бус, амжилт, хөгжил, амьдралын ахиц гэх зүйрлэсэн эерэг үнэлэмж хандлагыг илэрхийлнэ. Харин урагшгүй, урагшгүйтэх нь “зогсолт”, “бүтэлгүйтэл”, “амьдралын саад” гэсэн сөрөг үнэлэмж, хандлагын илэрхийлэл юм. Ингээд урагш бол ахиц, амжилт, дэвшил; урагшгүй бол бүтэлгүйтэл, зогсонги байдал, бууралт гэсэн зүйрлэл үүсэж байна.

“Наана – Цаана” гэсэн орон зайн үгтэй хэлцүүд: *наашаа эргэх, өргөс нь цаанаа, өнгө нь наанаа, гүвээний цаанаас тархидах, цаашлуулах, цааш харах, цааш харуулах, наашаа ч үгүй цаашаа ч үгүй, наанатай цаанатай, амь наана, там цаана* гэх мэт байна. Эндээс харахад “наана / цаана” гэсэн орон зайн нэр нь ойр–хол, амьд–үхэл, ил–далд, эерэг–сөрөг гэсэн танин мэдэхүйн эсрэгцлийн үндэс болж, мөн эндээс танин мэдэхүйн зүйрлэлийг харж болохоор байна.

Хүснэгт 2. Наана, цаана үгсээр бүтэх зүйрлэл

Танин мэдэхүйн зүйрлэл	Дүрслэл	Жишээ
Ойр бол сайн	Ойр буй зүйл эерэг, амьдралтай холбогдоно	наашаа эргэх, наанатай цаанатай
Хол бол муу, аюултай	Хол талд буй зүйл үхэл, далд, муу утгатай	цааш харах, цааш харуулах, долоон уулын цаагуур
Урагш бол ахиц, сайжрал	Дотогш, ойр чиглэл сайжрал илтгэнэ	наашаа эргэх
Ард/цаана бол нууц, төгсгөл	Далд орон зайд нуух, дуусах утга илэрнэ	өргөс нь цаанаа, гүвээний цаанаас тархидах

Хүснэгт 3. Наана–цаана гэх чиглэлийн эсрэгцэл

Утга	Эерэг ойлголт	Сөрөг ойлголт
Орон зайн утга	Наана – ойр, ил, амьд	Цаана – хол, далд, үхэл
Сэтгэлзүйн утга	Наашаа эргэх – сайжрах	Цааш харах – үхэх
Нийгмийн утга	Наанатай цаанатай – уян хатан	Цаашлуулах – егөөдөх
Хөдөлгөөн / Амьдрал	Наашаа – сэргэлт, амьдрал	Цааш – төгсгөл, мөхөл

Хүснэгт 2 ба 3-аас харахад: монгол хэлний “наана–цаана” гэсэн орон зайн эсрэгцлээр амьдрал ба үхэл, ил тод ба далд, ойр дотно ба хөндий хол, амжилт ба бүтэлгүйтэл гэсэн танин мэдэхүйн хийсвэр ойлголтуудыг илэрхийлж байна. Тухайлбал: “наашаа эргэх” гэсэн хэлц нь амьдрал, эдгэрэл, бүтэмжтэй байх хөдөлгөөний утгыг илэрхийлдэг болдог бол, “цааш харах” нь үхэл ба алсралын утга санааг илэрхийлж байна.

Ар, ард гэсэн үгээс бүтсэн: **араар суух** (а. хойгуур суух; б. хойргоших), **араар явах** (хойгуур явах), **араар нь гарах** (хойгуур нь гарах), **ар хударгаар нь үйлдэх** (хориотой, цээртэй үйлийг эзгүйчлэн амжуулах), **араар (нь) тавих** (а. нүднээс далдуур чадах, хуурч мэхлэх, дөнгөх, давах; б. эхнэр буюу нөхрөөсөө далдуур өөр хүнтэй явалдах), **араараа тавиулах** (бусдад дөнгүүлэх, мэхлүүлэх), **арын хаалгадах** (танил талаа ашиглан ажил үйлсээ бүтээх, хэрэг явдлаа гүйцээх), **ард орох** (хойно орох), **ард нь бичих** (ар талд нь бичих) **ард нь гарах** (а. юмны ар талд гарах; б. эхэлсэн ажил үйлсийг амжилттай дуусгах) **ардаа орхих** (а. цаг хугацааг туулах; б. бусдаасаа нэгэнт түрүүлэх), **ард үлдэх** (а. цаг хугацаа улиран өнгөрөх; б. хойш суух, бусдаас хоцорч үлдэх), **\*хүний ард орох** (а. хүний ард нуугдах; б. хүмүүсээс хоцрох) зэрэг хэлцийн бүтцэд буй “араар”, “хойгуур”, “ард” зэрэг орон зайн утгат үгс нь **далд, шууд бус үйлдлийг** илэрхийлэхэд хэрэглэгдэж байна. Товчилбол:

- *Ард үлдэх* → хоцорч үлдэх, идэвхгүй байх
- *Хойно суух* → бусдад мэдэгдэхгүй, алгуурлах

• *Араар суух* → далд, хуурч мэхлэх гэх мэтээр хоцролт, бүтэлгүйтэл, далд, өнгөрсөн гэсэн ерөнхий утгыг илэрхийлэхийн зэрэгцээ монгол хэлэн дэх баримжааны зүйрлэлийн сонгодог жишээ болж бидний бие махбодын орон зайг ашиглан амжилт, бүтэлгүйтэл, идэвх, сөрөг байдал зэрэг хийсвэр ойлголтуудыг илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Өөд, уруу гэх чиглэл заасан үгсээс бүтсэн хэлцийн утга, зүйрлэл

Хэлц хэллэг	Шууд утга	шилжсэн утга / танин мэдэхүйн утга
өөд нь татах	дээш татах	Сайжруулах, дэмжих — <b>ӨӨД</b> → “дээд, сайхан, амжилт руу чиглэх хөдөлгөөн”
өөд болох	дээш гарах, дэвших	Нас барах — <b>ӨӨД</b> → “дээд ертөнц, тэнгэр рүү гарах”
өөдөө гарах	дээш гарах	Албан тушаал ахих, амьдрал сайжрах — <b>ӨӨДӨӨ</b> → “амжилт, хөгжил рүү чиглэх хөдөлгөөн”
өөд уруугүй	хоёр чиглэлгүй, ялгаагүй	Хаашаа ч хамаагүй, хайнга — <b>ӨӨД / УРУУ</b> → “чиглэлгүй, зорилгогүй”
өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр	дээш чулуу шидэх	Хийсэн муу үйл эргэж өөрт ирэх — <b>ӨӨДӨӨ</b> → “үйл ба үр дагаврын эргэх хөдөлгөөн”
толгой өөд татахгүй	дээш харахгүй	Завгүй, амсхийх завгүй — <b>ӨӨД</b> → “сэргэх, чөлөөтэй байх”-ын эсрэг утга
зовхи нь өөдөө	зовхи дээш	Сэргэлэн, цовоо — <b>ӨӨД</b> → “нээлттэй, гэрэлтэй, амьд эрч хүчтэй”
уруу татах	доош татах	Бусдыг муу үйлд татах — <b>УРУУ</b> → “доройтол, ёроол руу чиглэх”
уруу татагдах	доош чиглэх хөдөлгөөнд автах	Бусдын муу нөлөөнд автах — <b>УРУУ</b> → “ёс суртахууны доройтол”
уруу царайлах	доош харах	Гуниглах, гутрах — <b>УРУУ</b> → “сэтгэл унасан, доройтсон төлөв”
уруу царайлж уутан малгайлах	дорой царай гаргах	Ядарсан, гунигтай — <b>УРУУ</b> → “бие, сэтгэлийн доошлох хөдөлгөөн”
уруудах	доош буух	Бүтэлгүйдэх, доройтох — <b>УРУУДАХ</b> → “амьдралын түвшин унах”
уруудахад буруудах	доош унаад буруу зам олох	Улам муудах — <b>УРУУ</b> → “ёс суртахуун, амжилтын бууралт”
уруугаа харж усан нүдлэх	доош харан уйлах	Гуниглах, зовох — <b>УРУУ</b> → “сэтгэлзүйн дорой байдал”

Хүснэгт 4-өөс харахад “ӨӨД / УРУУ” чиглэл заасан үгсээс бүтсэн хэлцүүд нь монгол хүний **босоо чиглэлийн орон зайн сэтгэлгээг** тусгасан байна. Өөд гэвэл дээш, тэнгэр өөд чиглэсэн хөдөлгөөн, уруу гэвэл доош, газар уруудсан хөдөлгөөн болно. Өөд нь амьдрал, гэрэл, амжилт, дэвшил гэсэн зүйрлэлийг үүсгэж байхад уруу нь доройтол, үхэл, гуниг гэсэн зүйрлэлийг үүсгэж байна. Энэ хослол нь Ж.Лакофф, М.Жонсоны “Conceptual Metaphor Theory”-ийн **“GOOD IS UP / BAD IS DOWN”** схемтэй бүрэн нийцэж байна.

Монгол хэлний гадар, гадуур, дотор, дотуур гэсэн байрлал заасан үгсийн

шууд ба шилжсэн утгыг хэлцийн бүтцээс лавлан тодруулж үзвэл баримжааны зүйрлэлүүд илүү олноор үүсэж байгааг харж болно. Ялангуяа дотор, дотуур гэсэн үгийн хувьд харьцангуй олон жишээ илэрч байгаа нь монголчууд өөрийн биеийн дотоод ертөнцийг өвөрмөцөөр хийсвэрлэн сэтгэдэгтэй холбон үзэж болно.

*Хүснэгт 5. Дотор, дотуур гэсэн үгээс бүтсэн хэлцийн утга, зүйрлэл*

Хэлц	Шууд утга	Шилжсэн утга	Танин мэдэхүйн зүйрлэл, тайлбар
дотор санаа	биеийн доторх сэтгэл	дотоод муу бодол	дотоод орон зай = сэтгэл, дотоод мэдрэмжийг төсөөлөх.
хар дотортой	дотор нь хар	муу сэтгэлтэй	дотоодын хар өнгө = буруу санаа, муу бодол.
дотор нь долоон нохой үхэх	дотор муудах	мулгуу, ухаан муутай	оюун ухаан = дотоод орон зай; доройтсон нь “дотор муудах”.
дотуур тамиртай	биеийн дотуур хүчтэй	муу санаатай	дотоод орон зайд нуугдсан санаа.

Эдгээр дотор гэсэн үгээс “**дотоод ертөнц бол сэтгэл санаа / оюун бодол**” гэсэн зүйрлэл үүсэж байна. Харин дараах хүснэгтээс дотор бол сав юм гэсэн зүйрлэл харагдана.

*Хүснэгт 6. Дотор бол сав гэсэн зүйрлэлийн жишээ*

Хэлц	Шууд утга	Шилжсэн утга	Танин мэдэхүйн зүйрлэл
дотор онгойх / цэлмэх	дотоод зай нээгдэх	Сэтгэл амрах	сэтгэл = сав; нээлттэй = амгалан тайван.
дотор нь ороод гарсан юм шиг	доторхыг нь мэдэх	Хүн, аливааг бүрэн ойлгох	оюуны нэвтрэлт, ойлгох процесс = дотоод орон зайд орж гарах.

Монголчуудын үзэл ойлголтоор бол биеийн дотор нь сэтгэл гэгч хийсвэр эрхтэн оршдог. “Сэтгэл” гэх үг монгол хэлний хэрэглээнд монгол хүний дотоод ертөнцийн хандлага, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл, хүний ёс суртахуун, зан үйлийг тусгах ба **сэтгэлд бүх зүйл агуулагдаж, сэтгэлээс бүх зүйл төрнө** гэсэн үзэл хандлагатай байдаг. Танин мэдэхүйн зүйрлэлийн онолын үүднээс оршихуйн зүйрлэлийн нэг төрөл болох сав багтаамжийн зүйрлэлийн хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, монгол хэлний “дотор” гэсэн орны нэрсээс үүссэн хэлцүүд нь сав буюу CONTAINER image schema–д суурилсан ontological metaphor–ийн илрэл бөгөөд “СЭТГЭЛ БОЛ САВ”, “ХҮН БОЛ ДОТООД ОРОН ЗАЙТ БИЕ” гэсэн зүйрлэлүүдийг илтгэнэ. Ингэж дотор гэсэн орны утгат үгээр илрэх сэтгэл буюу хүний дотоод ертөнц нь сав буюу орон зайт бие болж, энэ нь нээлттэй байх үед амгалан оршино гэсэн утга агуулгыг илэрхийлж байна.

Монгол хэлний баруун, зүүн гэх зүг чигийн байрлал заах үгсээр бүтсэн цөөн хэлц байна. Жишээ нь: **баруун гар** (зөв гар, зөв тал; **баруун зүүнээрээ солих** (гараас гарт шилжүүлэн бэлэн солих, бэлнээр наймаалах), **баруун зүүнгүй** (баруун солгойгүй, аль аль талаараа), **баруун солгойгүй** (а. Ажил хэргийг хийж гүйцэтгэхдээ дадамгай, сурамгай; б. Зөв буруу үнэн худлыг ялгахгүй; в. Баруун зүүнгүй), **баруун солгойгүй хүн** (ямар нэгэн ажил үйлийг хийж гаршсан хүн), **зүүн гар** (шадар туслах) гэх мэт.

Эдгээр хэлцээс монгол хэлний сэтгэлгээн дэх баруун, зүүн гарын суурь танин мэдэхүйн ялгаа тодорхой харагддаг. Хүснэгтээр 7-оор харуулбал:

*Хүснэгт 7. Баруун, зүүн гарын суурь танин мэдэхүйн ялгаа*

Туршлагын суурь	Танин мэдэхүйн ялгаа	зүйрлэлийн утга
Ихэнх хүн баруун гараа голлон ашигладаг	<b>Баруун = хүчтэй, чадвартай, зөв, итгэлтэй тал</b>	ЗӨВ, ИТГЭЛ, ЧАДВАР
Зүүн гар бага хэрэглэгддэг	<b>Зүүн = сул, туслах, сөрөг, “өөр” тал</b>	ТУСЛАХ, БУРУУ, ХАРЬ ТАЛ

Танин мэдэхүйн туршлага дээр суурилсан “САЙН нь БАРУУН”, “МУУ нь ЗҮҮН” гэсэн зүйрлэл үүсэж байна.

Баруун зүүнгүй / баруун солгойгүй гэсэн хэлцийн хувьд, аль ч гараар хийж чадна гэсэн шууд утгыг илтгэж, харин биед суурилсан танин мэдэхүйн сэтгэлгээний хүрээнд хоёр гараа чөлөөтэй ашиглах туршлагаас олон талын ур чадварын төсөөлөл бий болж “баруун зүүнгүй буюу олон талт чадвар гэсэн шилжсэн утгыг илэрхийлж гар бол ур чадвар юм гэсэн зүйрлэл бүтжээ. Энэ мэтчилэн монгол хэлний танин мэдэхүйн сэтгэлгээнд “баруун” нь **чадвар, итгэл, зөв тал**, “зүүн” нь **туслах, сул, эсрэг тал** гэсэн **танин мэдэхүйн зүйрлэл** үүсэж, харин дээрх хэлцийн гүн утга нь биеийн мэдрэмжээс нийгмийн ойлголт, улмаар ёс суртахууны ангилал руу өргөжин хөгждөг болохыг илтгэж байна.

### Судалгааны үр дүн

Орчин цагийн монгол хэлний орон, байр, зүг чигийн утгатай үгс нь олон янзын утга, үүргээр хэрэглэгдэж байгааг өмнөх эрдэмтдийн судалгаа шинжилгээний ажлуудтай харьцуулан, орчин үеийн танин мэдэхүйн хэл шинжлэлийн онолын үүднээс задлан шинжилж үзлээ. Дээр, доор, өмнө, хойно зэрэг үг нь утга ба хэрэглээний дараах хэдэн онцлогтой байна. Үүнд:

1. Өвөрмөц хэлцийн бүтцэд орж тодорхой байршил заах үндсэн утгаа илэрхийлж байна.
2. Босоо, хэвтээ тэнхлэгийн харьцаанд цаг хугацааны утга илэрхийлж байна.
3. Тухайн тохиолдолд хоёр зүйлийн харьцааг илэрхийлж шинж чанарын хэмжүүр болж байна.
4. Хэд хэдэн үйл явдал, үйл хөдлөл давхардах, зэрэгцэх гэсэн утгыг илтгэж тэдгээрийг хооронд нь холбох хэл зүйн үүрэгтэй байна.
5. Бодит зүйлсээс гадна хийсвэр зүйлийн харьцаа хамаарлын утгыг илэрхийлж байна.
6. Тооны хувьд *дээр, дотор* гэсэн орших орны утга илэрхийлэх үгээс бүтсэн өвөрмөц хэлц хамгийн олон байна. Ялангуяа *дотор* гэсэн үгээс бүтсэн өвөрмөц хэлц илүү олон байгаа нь өөрийн биеэр төв болгож зүйрлэн

илэрхийлэх сэтгэлгээний онцлогтой холбоотой гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, монголчууд сэтгэл хэмээх зүйлийг өөрийн дотор байдаг гэж үзэх бөгөөд сэтгэл санаагаа биеийн дотор тал хэмээн зүйрлэн сэтгэж, сэтгэл санааны олон янз байдал буюу дотоод дахь сэрэл мэдрэмжээ *дотор онгойх, дотор харанхуйлах, дотроо уудлах* гэх мэт үгээр илэрхийлдэгтэй холбоотой.

7. *Дээрдэх-доордох, доторлох-гадарлах, урагштай-урагшгүй* зэргээр харилцан эсрэгцсэн утгатай орны нэрсээр шууд бус нэрлэлт үүсэж байна. Энэ нь монголчуудын аливаа юмс үзэгдлийг эсрэгцүүлэн таньж мэдсэнийхээ үндсэн дээр зүйрлэн харьцуулж илэрхийлэх сэтгэлгээний онцлогийг илтгэх ажээ.
8. Орны нэрээс үүссэн үйл үгийн утга шилжиж өвөрмөц хэлц үүссэн жишээ цөөнгүй байна. Жишээ нь: *уруудах, урагшгүйтэх, хажуулах, өөдлөх, хойшлох* гэх мэт. Энэ нь өөрөөрөө төв болгох орон зайн танилтын үр дүнд төдийгүй биед суурилсан туршлагын үр дүнд зүйрлэн сэтгэх онцлогийг илэрхийлж байна гэж үзэж болох юм.
9. Орны нэрс шууд утгаараа өвөрмөц хэлцийн бүтцэд орж төрөл бүрийн орон байрын утга илтгэх нь дийлэнх байна. Өөрөөр хэлбэл, туслах үгийн үүргээр орсон тохиолдолд үндсэн буюу шууд утгыг илэрхийлж байна. Жишээ нь: *толгой дээр гарах, хоёрын хооронд гурвын дунд, ниргэсэн хойно хаширах* гэх мэт.

## Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс дараах онолын дүгнэлт гарч байна.

1. Монгол хэлний “дээр, доор, өмнө, хойно, дотор, гадна, наана, цаана, өөд, уруу” зэрэг орон зайн нэр нь зөвхөн байршлын шууд утгыг илэрхийлэх бус, харин нийгмийн шатлал, ёс суртахууны үнэлэмж, сэтгэл зүйн төлөв байдал, цаг хугацааны зохион байгуулалт, амьдралын хөдөлгөөн, амжилт–бүтэлгүйтэл зэрэг хийсвэр хүрээг илэрхийлэх танин мэдэхүйн суурь болж байгаа юм. Ингэснээр монгол хэлэнд дараах танин мэдэхүйн зүйрлэлүүд тогтвортой илэрч байна. Үүнд:

САЙН БОЛ ДЭЭР (GOOD IS UP)/ МУУ БОЛ ДООР (BAD IS DOWN)

ЦАГ ХУГАЦАА БОЛ ОРОН ЗАЙ (TIME IS SPACE)

НИЙГМИЙН БАЙР СУУРЬ БОЛ БОСОО БАЙРЛАЛ (SOCIAL STATUS IS VERTICAL POSITION)

АМЬДРАЛ БОЛ ХӨДӨЛГӨӨН (LIFE IS MOVEMENT)

ОЮУН УХААН /СЭТГЭЛ БОЛ САВ (MIND/HEART IS A CONTAINER)

Эдгээр нь монгол хэлний хэлцийн тогтолцоонд санамсаргүй бус, тогтвортой давтагдаж буй бүтэц гэж үзэж болно.

2. Судалгаанд “дээр–доор”, “өөд–уруу” зэрэг босоо чиглэлийн эсрэгцэл хамгийн баялаг хэлц үүсгэж буй нь тогтоогдов. Энэ нь үнэлэмж, эрх мэдэл, амжилт, амьдралын хөдөлгөөн зэргийг босоо байрлалаар зохион байгуулдаг танин мэдэхүйн хэв шинж давамгайл байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, босоо чиглэл нь монгол хэлний үнэлэмжийн тогтолцоог илэрхийлэх гол загвар болдог.

3. Монгол хэлний “дотор” гэсэн орны нэрээс үүссэн хэлцүүд нь CONTAINER image schema–д суурилсан сав багтаамж зүйрлэл (ontological metaphor)–ийн илрэл бөгөөд “СЭТГЭЛ БОЛ САВ”, “ХҮН БОЛ ДОТООД ОРОН ЗАЙТ БИЕ” гэсэн зүйрлэлийг илтгэнэ. “Дотор онгойх”, “дотроо уудлах”, “хар дотортой” зэрэг хэлц нь сэтгэл, оюун санаа, ёс суртахууны чанарыг биеийн дотоод орон зайгаар дамжуулан ойлгож буйг харуулж байна. Энэ нь биеэр танин мэдэхүйн зарчимтай бүрэн нийцэж, хүний бие махбодын туршлага нь хийсвэр дотоод ертөнцийг зохион байгуулах загвар болж буйг баталж байна.

4. Судалгаанд орон зайн нэрс ихэнхдээ эсрэгцсэн хос бүтэц (дээр–доор, өмнө–хойно, наана–цаана, өөд–уруу) хэлбэрээр илэрч, хийсвэр ойлголтыг эсрэгцлийн зарчмаар танин мэдэх, илэрхийлэх хандлага давамгайл байгааг тогтоов. Энэ нь монгол хэлний танин мэдэхүйн зохион байгуулалт хосолмол бүтэцтэй болохыг харуулж байна. Ийм зохион байгуулалт нь үнэлэмжийн ангилал, нийгмийн харилцаа, цаг хугацааны ойлголт, ёс суртахууны ялгааг бүтэц, тогтолцоонд оруулах чухал үйл явц болж байна.

5. Орон зайн харьцааны нэрсийг уламжлалт хэл зүйн ангиллаар дайвар үг, нэр үг, завсрын шинжтэй нэгж гэх мэтээр тодорхойлж ирсэн боловч энэхүү судалгааны үр дүнгээс харахад тэдгээрийг зөвхөн хэл зүйн ангиллаар хязгаарлах боломжгүй байна. Учир нь эдгээр үгсийн гол онцлог нь өгүүлбэр зүйн байрлал бус, харин танин мэдэхүйн үүрэг буюу хийсвэр ойлголтыг бүтэцжүүлэх үйл явц юм. Иймээс орон цагийн нэрсийг хэлний танин мэдэхүйн утга зүйн түвшинд судлах нь тэдгээрийн утга, хэрэглээг илүү тодорхой болгох боломжтойг харуулж байна.

### Судалгааны онолын ач холбогдол

Энэхүү судалгаа нь монгол хэлний орон зайн нэрсийг танин мэдэхүйн онолын хүрээнд тогтолцоотой задлан шинжилснээр:

1. Монгол хэлний хийсвэр ойлголтын бүтэц, тогтолцоо нь биед суурилсан, хүн төвт шинжтэй болохыг нотлов.

2. Орон зайн нэрс нь хэл зүйн туслах нэгж бус, харин хийсвэр сэтгэлгээний үндсэн тулгуур ойлголт болохыг тогтоов.

3. Монгол хэлэнд танин мэдэхүйн зүйрлэлүүд илэрч буй ч тэдгээрийн давтамж, бүтэц нь соёл–сэтгэлгээний өвөрмөц онцлогтой болохыг тодруулан үзэв.

Ингэснээр орон цагийн нэрс нь монгол хэлний утга зүйн тогтолцоонд голлох байр суурь эзэлж, нийгэм–соёл–сэтгэлгээний гүн давхаргыг тусган илэрхийлдэг танин мэдэхүйн зангилаа нэгж болох нь тогтоогдож байна. Цаашид монгол хэлний орон зайн зүйрлэлийг бусад хэлтэй харьцуулсан хэв шинжийн судалгаа, мөн корпусын өгөгдөлд тулгуурласан тоон шинжилгээ хийх нь танин мэдэхүйн хэл шинжлэлд чухал хувь нэмэр оруулах боломжтой юм.

### Ном зүй

Баянсан, Ж. (2016). *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ* (Нэмж зассан 2 дахь хэвлэл). Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр. (Анхны хэвлэл 2002).

Баянсан, Ж. (2022). *Монгол хэл судлал*. XIV боть, Танихуйн хэл шинжлэл-Хэлний соёл судлал. Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК, 371х.

Бямбасан, П. (2006). *Монгол хэлний онол, бүтцийн асуудалд*. Улаанбаатар: Бодьмөр хэвлэх үйлдвэр. 408х.

Бямбаханд, Ч. (2017). *Монгол хэлний орон цагийн харьцааны нэрийн утга, бүтцийн онцлог*. Улаанбаатар: Битпресс хэвлэлийн компани.

Лувсанвандан, Ш. (2019). *Орчин цагийн монгол хэлний бүтэц*. Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. III боть: Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь. Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК, 260х.

Магсар, Ц. (2012). *Цаг үе ба метафорчлох сэтгэлгээ*. “Лавай” МУБИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. №3. Улаанбаатар.

Лакофф, Ж., & Жонсон, М. (1980). *Metaphors We Live By*. Chicago: University of Chicago Press. [G. Lakoff, M. Johnson. (1980). *Metaphors We Live By*. Chicago: University of Chicago Press.]

Лакофф, Ж. (1993). *The contemporary theory of metaphor*. In A. Ortony (Ed.), *Metaphor and thought* Cambridge: Cambridge University Press. [Lakoff, G. (1993) *The contemporary theory of metaphor*. In A. Ortony (Ed.), *Metaphor and thought* Cambridge: Cambridge University Press.]

Монгол хэлний цахим тайлбар толь. <https://mongoltoli.mn/dictionary/detail/82458>

## Abstract

This paper examines spatial–temporal relational nouns in contemporary Mongolian from the perspective of cognitive linguistics, drawing on the framework of Conceptual Metaphor Theory proposed by George Lakoff and Mark Johnson. The study analyzes idiomatic expressions containing spatial terms extracted from the Electronic Explanatory Dictionary of the Mongolian Language and various Mongolian idiom dictionaries. These expressions were selected and examined to identify the relationship between their literal and metaphorical meanings.

Based on the theory of embodied cognition, the study demonstrates that spatial terms such as *deer* (above), *door* (below), *ömno* (in front), *hoino* (behind), *dotor* (inside), *gadna* (outside), *naana* (this side), and *tsaana* (that side) function not only to denote physical location but also as fundamental cognitive mechanisms for conceptualizing abstract domains. These include social hierarchy, value judgments, emotions, morality, temporal relations, and life processes.

The findings indicate that vertical spatial metaphors (UP–DOWN) are particularly prominent in Mongolian, reflecting the conceptual pattern GOOD IS UP / BAD IS DOWN. In addition, terms such as *dotor* (“inside”) frequently realize the CONTAINER metaphor, conceptualizing the human mind and emotions as an internal space (e.g., THE MIND IS A CONTAINER). The study further reveals that spatial oppositions form a system of binary cognitive organization in Mongolian conceptualization.

Overall, the results demonstrate that spatial–temporal relational nouns constitute core conceptual structures through which abstract meanings are expressed in Mongolian. These linguistic units reflect a strongly embodied and anthropocentric cognitive pattern, highlighting the role of bodily experience in structuring Mongolian linguistic and conceptual systems.